

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/22/НА-СТА-ТЕЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тусгай чиг үүргийн газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан Утас:261665 Цахим хаяг: <a href="mailto:bayarsaikhand@audit.gov.mn">bayarsaikhand@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:dolqorsurenb@audit.gov.mn">dolqorsurenb@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор П.Амарсанаа Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:amarsanaap@audit.gov.mn">amarsanaap@audit.gov.mn</a></p> <p>Аудитор Н.Нямсүрэн Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:nyamsurenn@audit.gov.mn">nyamsurenn@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал.....	11
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	17
3.5.4 Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл.....	17
3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт .....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	20
4.1 Ерөнхий зүйл .....	20
4.2 Материаллаг байдал .....	20
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	20
4.4 Судалгааны үр дүн .....	21
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	22
5.1 Албан шаардлага .....	22
5.2 Зөвлөмж .....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн Газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
САГ	Санхүүгийн аудитын газар
СМНС	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.24 № 1127  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд албан ёсны статистикийн 6 бүлгийн 859 статистик үзүүлэлтийг тогтмол давтамжтай боловсруулан мэдээлж, 2 тооллого, 9 түүвэр судалгаа зохион байгуулсан байна. Төрийн 15 байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийг ашиглан, нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, Хүн ам орон сууцны завсрын тооллогыг зохион байгуулсан нь төсвийг 2.2 дахин хэмнэж, тооллогын үр дүнг гаргаж, тархаах хугацаа 1.5 дахин бууруулсан үзүүлэлттэй байна. Үүний үр дүнд 10 жил тутамд зохион байгуулдаг хүн ам орон сууцны тооллого, 5 жил тутамд хийдэг аж ахуй нэгжийн тооллогыг хумигдсан үзүүлэлтээр жил бүр зохион байгуулах системийг хөгжүүлж, тус өгөгдлийг төрийн болон хувийн хэвшлийн бодлого шийдвэрт ашиглах боломжийг нэмэгдүүлсэн байна. Хүн ам орон сууцны завсрын тооллого, Мал, тэжээвэр амьтдын тооллогод 2020 онд 4,286.4 сая төгрөг зарцуулж, байсан бол 2025 онд нийт 2,217.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр хийгдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, 4 удаа тодотгол хийсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,000.0 сая төгрөгийн төсөв баталснаас 1,804.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 6.5 сая төгрөгийн алданги тооцон суутгаж, 1,797.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 202.1 сая төгрөг, урсгал төсвийн худалдан авах ажиллагаанаас 121.1 сая төгрөгийг тус тус хэмнэж, ажилласан байна.

## **Бусад асуудал**

Статистикийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын үр дүнд 2025 онд НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын статистикийн институтын удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон мөн Дэлхийн банкны гүйцэтгэлийн үнэлгээгээр Зүүн Ази, Өмнөд Ази, Номхон далайн орнуудаас 7 дугаар байр, дэлхийд 47 дугаар байранд орж, 5 байраар урагшилсан байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>951,846.1</b>	<b>824,414.3</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,570.6	100.6
33	АВЛАГА	125,596.9	203,757.1
34	УРЬДЧИЛГАА	362,091.2	185,454.8
35	БАРАА МАТЕРИАЛ	442,587.5	435,101.8
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,236,909.5</b>	<b>4,382,435.9</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,236,909.5	4,382,435.9
39200	Биет хөрөнгө	3,164,203.2	4,125,312.6
39300	Биет бус хөрөнгө	72,706.3	257,123.3
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,188,755.6</b>	<b>5,206,850.2</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,973.7</b>	<b>24,384.2</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,973.7	24,384.2
41300	Өглөг	1,973.7	24,384.2
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,186,781.9</b>	<b>5,182,466.0</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,186,781.9	5,182,466.0
51200	Хуримтлагдсан үр дүн	4,183,648.5	5,179,332.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,133.4	3,133.4
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,188,755.6</b>	<b>5,206,850.2</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,602,266.1</b>	<b>31,566,296.7</b>
<b>2</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>467,667.5</b>	<b>1,127,983.8</b>
<b>3</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>467,667.5</b>	<b>1,127,983.8</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>23,134,598.6</b>	<b>30,438,312.9</b>
<b>5</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>24,396,100.2</b>	<b>30,042,652.5</b>
<b>6</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>24,396,100.2</b>	<b>30,042,652.5</b>
<b>7</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>22,977,820.0</b>	<b>28,513,699.2</b>
<b>8</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,961,503.4</b>	<b>17,113,613.1</b>
<b>9</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,614,057.6</b>	<b>2,182,035.2</b>
<b>10</b>	<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>674.2</b>
<b>11</b>	<b>Нормативт зардал</b>	<b>700,968.1</b>	<b>1,029,275.2</b>
<b>12</b>	<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	<b>9,131.0</b>	<b>595.2</b>
<b>13</b>	<b>Томилолт зочны зардал</b>	<b>126,693.9</b>	<b>95,410.5</b>
<b>14</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>546,757.7</b>	<b>381,943.7</b>
<b>15</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,145,826.3</b>	<b>5,917,057.8</b>
<b>16</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,872,881.9</b>	<b>1,793,094.5</b>
<b>17</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,418,280.2</b>	<b>1,528,953.3</b>
<b>18</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>(793,834.1)</b>	<b>1,523,644.2</b>
<b>19</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>6,953.2</b>
<b>20</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>15,783.0</b>	<b>533,087.5</b>
<b>21</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>(15,783.0)</b>	<b>(526,134.4)</b>
<b>22</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>(809,617.1)</b>	<b>997,509.9</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,001,933.8</b>	-	<b>5,001,933.8</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(5,534.8)	-	(5,534.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,996,399.0	-	4,996,399.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	(809,617.1)	-	(809,617.1)
10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,186,781.9</b>	-	<b>4,186,781.9</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,825.7)	-	(1,825.7)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,184,956.2	-	4,184,956.2
19	Тайлант үеийн үр дүн	997,509.8	-	997,509.8
20	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,182,466.0</b>	-	<b>5,182,466.0</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<b>23,298,998.7</b>	<b>30,556,858.1</b>
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>8,932.6</b>	<b>30,556,858.1</b>
3	Нийтлэг татварын бус орлого	8,932.6	-
4	Тусламжийн орлого	-	30,556,858.1
5	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,290,066.0	-
6	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<b>23,281,290.6</b>	<b>28,779,730.2</b>
7	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>23,281,290.6</b>	<b>28,779,730.2</b>
8	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>21,743,661.3</b>	<b>27,052,224.4</b>
9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,382,877.6	16,933,065.0
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,610,447.6	2,173,277.5
11	Хангамж бараа материалын зардал	502,929.9	888,308.5
12	Эд хогшил урсгал засварын зардал	164,957.4	161,137.0
13	Томилолт зочны зардал	548,719.2	383,653.7
14	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,099,845.1	6,316,137.5
15	Бараа үйлчилгээний бусад зардал	433,884.5	196,645.1
16	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>1,537,629.3</b>	<b>1,727,505.9</b>
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,708.1	1,777,127.9
18	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	24,970.1	1,798,597.9
19	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>24,970.1</b>	<b>1,798,597.9</b>
20	Дотоод эх үүсвэрээр	24,970.1	1,798,597.9
21	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	<b>(24,970.1)</b>	<b>(1,798,597.9)</b>
22	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	<b>(7,262.0)</b>	<b>(21,470.1)</b>
23	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>28,832.6</b>	<b>21,570.6</b>
24	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>21,570.6</b>	<b>100.6</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	29,907,075,200.00	27,514,085,728.89	(2,392,989,471.11)	92.0
Татварын бус орлого	29,907,075,200.00	27,514,085,728.89	(2,392,989,471.11)	92.0
Тусламжийн орлого	29,907,075,200.00	27,514,085,728.89	(2,392,989,471.11)	92.0
Төсвөөс санхүүжих	29,907,075,200.00	27,514,085,728.89	(2,392,989,471.11)	92.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	<b>29,907,075,200.00</b>	<b>27,514,085,728.89</b>	<b>(2,392,989,471.11)</b>	<b>92.0</b>
Урсгал зардал	28,102,875,200.00	25,716,887,808.89	(2,385,987,391.11)	91.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	27,728,324,600.00	25,555,782,184.99	(2,172,542,415.01)	92.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,954,715,400.00	15,117,005,530.18	(837,709,869.82)	94.7
Үндсэн цалин	8,681,365,600.00	8,802,490,582.04	121,124,982.04	101.4
Нэмэгдэл	4,231,564,800.00	4,090,337,024.82	(141,227,775.18)	96.7
Унаа хоолны хөнгөлөлт	1,583,736,800.00	1,423,847,417.10	(159,889,382.90)	89.9
Урамшуулал	1,458,048,200.00	800,330,506.22	(657,717,693.78)	54.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,993,479,500.00	1,935,648,323.51	(57,831,176.49)	97.1
Тэтгэврийн даатгал	1,355,679,400.00	1,334,122,693.59	(21,556,706.41)	98.4
Тэтгэмжийн даатгал	159,514,600.00	153,948,403.41	(5,566,196.59)	96.5
ҮОМШӨ-ний даатгал	81,418,400.00	77,155,152.23	(4,263,247.77)	94.8
Ажилгүйдлийн даатгал	78,060,600.00	73,724,870.27	(4,335,729.73)	94.4
Эрүүл мэндийн даатгал	318,806,500.00	296,697,204.01	(22,109,295.99)	93.1
Хангамж, бараа материалын зардал	294,662,900.00	228,663,649.71	(65,999,250.29)	77.6
Бичиг хэрэг	76,927,900.00	58,649,419.05	(18,278,480.95)	76.2
Тээвэр, шатахуун	80,444,800.00	62,944,268.00	(17,500,532.00)	78.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	77,969,500.00	66,856,845.66	(11,112,654.34)	85.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,320,700.00	40,213,117.00	(19,107,583.00)	67.8
Эд хогшил, урсгал засварын зардал	159,201,300.00	110,357,150.00	(48,844,150.00)	69.3
Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	5,067,050.00	(4,932,950.00)	50.7
Урсгал засвар	149,201,300.00	105,290,100.00	(43,911,200.00)	70.6
Томилолт, зочны зардал	87,930,600.00	57,383,450.00	(30,547,150.00)	65.3
Дотоод албан томилолт	87,930,600.00	57,383,450.00	(30,547,150.00)	65.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,064,040,000.00	7,984,312,554.59	(1,079,727,445.41)	88.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,246,569,800.00	7,322,993,609.90	(923,576,190.10)	88.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,204,900.00	14,726,000.00	(478,900.00)	96.9
Даатгалын үйлчилгээ	26,780,000.00	7,645,106.69	(19,134,893.31)	28.5
Тээврийн хэрэгслийн татвар	4,741,900.00	1,741,032.00	(3,000,868.00)	36.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	701,100.00	242,000.00	(459,100.00)	34.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,069,600.00	528,614,426.00	(71,455,174.00)	88.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	169,972,700.00	108,350,380.00	(61,622,320.00)	63.7
Бараа үйлчилгээний бусад зардал	174,294,900.00	122,411,527.00	(51,883,373.00)	70.2

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	48,150,300.00	31,601,035.00	(16,549,265.00)	65.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	126,144,600.00	90,810,492.00	(35,334,108.00)	72.0
<b>ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>374,550,600.00</b>	<b>161,105,623.90</b>	<b>(213,444,976.10)</b>	<b>43.0</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	36,477,100.00	-	(36,477,100.00)	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	36,477,100.00	-	(36,477,100.00)	-
Бусад урсгал шилжүүлэг	338,073,500.00	161,105,623.90	(176,967,876.10)	47.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,453,800.00	44,904,872.00	(5,548,928.00)	89.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	147,088,900.00	33,703,103.40	(113,385,796.60)	22.9
Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,428,800.00	34,430,561.50	(9,998,238.50)	77.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	96,102,000.00	48,067,087.00	(48,034,913.00)	50.0
<b>ЗАРДАЛ</b>	<b>1,804,200,000.00</b>	<b>1,797,197,920.00</b>	<b>(7,002,080.00)</b>	<b>99.6</b>
Тоног төхөөрөмж	1,804,200,000.00	1,797,197,920.00	(7,002,080.00)	99.6
<b>АНГИЛАЛ</b>	<b>637</b>	<b>595</b>	<b>(42.0)</b>	<b>93.4</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>35</b>	<b>35</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	35	35	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>298</b>	<b>289</b>	<b>(9.0)</b>	<b>97.0</b>
Удирдах ажилтан	39	35	(4.0)	89.7
Гүйцэтгэх ажилтан	246	240	(6.0)	97.6
Үйлчлэх ажилтан	13	14	1.0	107.7
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>298</b>	<b>270</b>	<b>(28.0)</b>	<b>90.6</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	149	135	(14.0)	90.6
Ажлын албаны албан хаагч (АА)	105	105	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18	28	10.0	155.6
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	24	0	(24.0)	-
<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>(5.0)</b>	<b>16.7</b>
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	6	1	(5.0)	16.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,825,135,667.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,825,135,667.78
122	Тусламжийн орлого	6,825,135,667.78
1221	Хандив тусламж /дотоод/	6,825,135,667.78
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,825,135,667.78
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	712,372,831.35
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	936,536,059.98
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,016,161,969.45
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	160,064,807.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,579,966,566.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,579,966,566.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,578,116,566.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,816,059,453.79
210101	Үндсэн цалин	421,206,986.92
210102	Нэмэгдэл	294,392,011.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,104,013.00
210104	Урамшуулал	42,608,165.76
210105	Гэрээт ажлын хөлс	1,042,748,276.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	237,629,206.95
210201	Тэтгэврийн даатгал	188,971,536.35
210202	Тэтгэмжийн даатгал	16,008,180.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,384,400.91
210204	Ажилгүйдлийн даатгал	1,551,971.94
210205	Эрүүл мэндийн даатгал	28,713,116.86
2104	Хангамж, бараа материалын зардал	660,190,587.90
210401	Бичиг хэрэг	61,930,054.00
210402	Тээвэр, шатахуун	517,372,387.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,542,146.85
210404	Ном, хэвлэл	27,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,346,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,559,825.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,222,525.00
210602	Тавилга	9,517,300.00
210604	Урсгал засвар	11,820,000.00
2107	Томиллолт, зочны зардал	326,270,228.00
210701	Гадаад албан томиллолт	34,106,628.00
210702	Дотоод албан томиллолт	292,163,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,410,799,665.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,395,847,880.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	429,536.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,522,249.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,607,599.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,732,404.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,875,195.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,850,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,850,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,850,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	245,169,101.28
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(245,169,101.28)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(245,169,101.28)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Үндэсний статистикийн хороо “Монгол Улсын статистик мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ”, алсын хараагаа “Статистик хэрэглэгчдийг чанартай тоон мэдээллээр хангаж, нотолгоонд суурилсан бодлого, шийдвэрийн залгамжийг тасралтгүй хадгалан, статистикийн чадавхаараа дэлхийд тэргүүлнэ” гэсэн эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Дэлхийн нийтлэг чиг хандлага, дотоодын хэрэгцээнд нийцүүлэн статистикийн салбарын хөгжүүлэх, мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчлэх, чанартай тоон мэдээллээр хангах зорилтын хүрээнд “Статистикийн салбарын 2021-2025 оны стратегийн төлөвлөгөө”-г боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны А/114 дүгээр тушаалаар баталсан бөгөөд ирэх 5 жилийн “Статистикийн салбарын 2026-2030 оны стратегийн төлөвлөгөө”-г боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2025 оны А/150 дугаар тушаалаар баталсан байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээллийг шуурхай авах, мэдээллийн хоцрогдлыг бууруулах, төрд байгаа тусдаа мэдээллийн сангуудыг нэгтгэх, уялдуулах, нэгдсэн сан бий болгож хөгжүүлэх зорилгоор “Төрийн их өгөгдөл төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулан дараах 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, гүйцэтгэлээр 82.6 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Хүний нөөцийн хөгжлийг хангах;
3. Дэд бүтцийг сайжруулах;
4. Статистикийн мэдээлэл эрхлэн гаргах.

Монгол Улсад өгөгдлийн засаглалын суурь тогтолцоог бэхжүүлэх ажлыг төрийн бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, “Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан”, “Төрийн нэгдсэн өгөгдлийн сан” цахим талбаруудыг шинээр үүсгэж, “Үндэсний өгөгдлийн замын зураглал”-ыг боловсруулсан. Энэ ажлын хүрээнд 2025 онд төрийн 14 байгууллагын суурь болон төрөлжсөн 30 мэдээллийн санг ашиглан “Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого”-ыг бүртгэлд суурилсан аргаар зохион байгуулж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан буюу “Хүн ам, орон сууцны тооллого”, “Аж ахуйн нэгжийн тооллого”-ыг жил бүр зохион байгуулах систем хөгжүүлсэн байна.

Мөн статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд гар утасны өгөгдөл, их өгөгдөл, хиймэл оюун нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлсэн. Жилийн эцсийн мал тооллогод машин сургалт, хиймэл оюун ашиглах загварыг туршилтаар нэвтрүүлж, ажилласан. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын дэргэдэх “Хөгжиж буй орнуудын албан ёсны статистикийн чадавхыг бэхжүүлэх, өгөгдөлд суурилсан бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх” зорилготой PARIS21 буюу “21-р зуун дахь хөгжлийн статистикийн түншлэл” байгууллагатай хамтран Үндэсний Статистикийн хороо болон Google Foundation хамтран Монгол Улсад статистикийн системийн хиймэл оюуны бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл эхлүүлсэн байна.

Тооллого, судалгаа, захиргааны мэдээллийн задгай өгөгдөлд ажиллаж, дүн шинжилгээ, судалгаа хийх, Дата лаб буюу өгөгдлийн инженер болон аналит мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй өгөгдөл дээр ажилладаг, интернэт хандалтгүй, дотоод сүлжээг шинээр нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдлын стандартыг хангасан тусгай орчинд судалгаа, шинжилгээ хийх боломжийг олгож байгаагаараа онцлогтой байна.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин

Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Шилэн дансны тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Үндэсний статистикийн хорооны хяналт шалгалтын журам”-ын дагуу Дотоод аудитын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, 5 сэдвийн хүрээнд 13 удаагийн аудит хийснээс 94.0 хувьтай, 8 сэдвийн хүрээнд нийт 23 хяналт шалгалтыг хийсэн нь 97.5 хувьтай дүгнэгдсэн байна.

Дотоод аудитын газрын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хорооны даргын “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн батлах тухай” 2024 оны А/140 дугаар тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлан мөрдөж байна.

Хорооны хэмжээнд мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,206.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,018.1 сая төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	21.6	0.1	(21.5)
АВЛАГА	125.6	203.8	78.2
УРЬДЧИЛГАА	362.1	185,5	(176.6)
БАРАА МАТЕРИАЛ	442.6	435.1	(7.5)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,236.9	4,382.5	1,145.5
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,188.8</b>	<b>5,206.9</b>	<b>1,018.1</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2.0	24.4	22.4
Засгийн газрын хувь оролцоо	4,186.8	5,182.5	995.7
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,188.8</b>	<b>5,206.9</b>	<b>1,018.1</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан данснуудыг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан харуулбал:

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг болж, 21.5 сая төгрөгөөр буюу 99.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Б	1	2	3=2-1
Төрийн сангийн харилцах	21.5	-	(21.5)
Арилжааны банк дахь харилцах	0.1	0.1	-
<b>Дүн</b>	<b>21.6</b>	<b>0.1</b>	<b>(21.5)</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгийн 0.1 сая төгрөгийн үлдэгдэл нь Үндэсний статистикийн хорооны арилжааны банк дахь зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- **Нийслэлийн Статистикийн газар:** Нийслэлийн автобаазтай гэрээ хийж суудлын автомашин ашигласан ажил баримтаар нотлогдохгүй байгаа 8.5 сая төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлаас түүвэрлэн үзэхэд замын хуудас нь тайлангүй зарцуулалтыг хянаагүй 6.2 сая төгрөг, тогтмол зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил дансанд бүртгэсэн 5.2 сая төгрөг;
- **Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс:** Байгууллагын албан хаагчид болон гэрээгээр ажил гүйцэтгэдэг судлаачдын цалинг нийгмийн даатгалын тайланд үнэн зөв тайлагнасан боловч татварын байгууллагад дутуу тайлагнасан 3.1 сая төгрөг;
- **Говьсүмбэр аймаг дахь Статистикийн хэлтэс:** Анхан шатны баримтын бүрдэл дутуу албан томилолтын зардал олгосон 1.0 сая төгрөг, Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүй боловч, ур чадварын нэмэгдэл олгосон 0.7 сая төгрөг, ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 0.2 сая төгрөг;
- **Төв аймаг дахь Статистикийн хэлтэс:** Жолооч хөлсөлж явахдаа ажлын хөлс олгоогүй, төрийн албан хаагчдад олгох томилолтын зардал бодож олгосон 2.7 сая төгрөг;
- **Булган аймаг дахь Статистикийн хэлтэс:** Албан хаагчдын цалинг тооцож олгохдоо илүү, дутуу олгосон 0.5 сая төгрөг;
- **Увс аймаг дахь Статистикийн хэлтэс:** Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндэслэх шийдвэргүйгээр нэмэгдүүлэн олгосон 0.3 сая төгрөг, тээвэр шатахууны зардлаас 0.3 сая төгрөг;
- **Дорнод аймаг дахь Статистикийн хэлтэс:** Хоол, унааны хөнгөлөлтийг албан томилолтын зардалтай давхардуулан олгосон 0.3 сая төгрөг.

### 3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 203.8 сая төгрөг болж, өмнөх оноос 78.2 сая төгрөгөөр буюу 62.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.8	2.1	1.3
Татаас, санхүүжилтийн авлага	118.1	198.3	80.2
Байгууллагаас авах авлага	6.7	3.4	(3.3)
<b>Дүн</b>	<b>125.6</b>	<b>203.8</b>	<b>78.2</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлага дансны 203.8 сая төгрөгийн үлдэгдэлд олон улсын байгууллагуудаас олгодог судалгааны ажлын санхүүжилтийн 198.3 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл, нийгмийн даатгалын шимтгэл болон ажилчидтай холбоотой 5.5 сая төгрөгийн авлагууд тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- **Ховд аймаг дахь Статистикийн хэлтэс:** ХАОАТ-ын авлагын тооцоо нийлээгүй, авлага дутуу бүртгэсэн 364.0 сая төгрөг.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 185.5 сая төгрөг болж, өмнөх оноос 176.6 сая төгрөгөөр буюу 51.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	362.1	185.5	(176.6)
<b>Дүн</b>	<b>362.1</b>	<b>185.5</b>	<b>(176.6)</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны 185.5 сая төгрөгийн үлдэгдэлд Бодь электроникс ХХК-ийн 37.5 сая төгрөг, Могул сервис ХХК-ийн 50.6 сая төгрөг, Ди Эл Пи ХХК-ийн 97.4 сая төгрөгийн урьдчилж төлсөн лицензийн төлбөрүүд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- **Үндэсний статистикийн хороо:** Өгөгдлийн ажлын урсгал автоматжуулах программ, Python программчлалын хэлний пакеж удирдах программын лицензийн төлбөр нийт 112.7 сая төгрөгийг сар бүр тохируулах бичилт хийж бүртгээгүй, тайлант оны зардал бүртгэж, тайлагнасан.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 435.0 сая төгрөг болж, өмнөх оноос 7.6 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Б	1	2	3=2-1
<b>Түүхий эд материал</b>	<b>78.6</b>	<b>72.5</b>	<b>(6.1)</b>
Тусгай зориулалттай материал	75.1	68.6	(6.5)
Эм боох материал	3.3	3.7	0.4
Бэлэн бүтээгдэхүүн	0.2	0.2	-
<b>Хангамжийн материал</b>	<b>364.0</b>	<b>362.5</b>	<b>(1.5)</b>
Бичиг хэргийн материал	88.5	57.5	(31.0)
Аж ахуйн материал	178.0	218.7	40.7
Сэлбэг хэрэгсэл	48.2	44.0	(4.2)
Түлш, шатах тослох материал	9.6	2.6	(7.0)
Хүнсний материал	5.2	-	(5.2)
Бусад хангамжийн материал	34.5	39.7	5.2
<b>Дүн</b>	<b>442.6</b>	<b>435.0</b>	<b>(7.6)</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материал дансны 435.0 сая төгрөг болж, өмнөх оноос 7.6 сая төгрөгөөр буурахад тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,671.3 сая төгрөг, шатахууны урамшуулал 4.1 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 1,147.6 сая төгрөг, төсвийн ерөнхийлөн захирагчаас харьяа байгууллагуудад шилжүүлсэн 524.9 сая төгрөг, Нийслэлийн статистикийн газрын акталж, данснаас хассан 10.5 сая төгрөгөөр тус тус хасагдсан нь нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- **Говьсүмбэр аймаг дахь Статистикийн хэлтэс:** Жилийн эцсийн байдлаар бараа материалын тооллого хийгдээгүй 0.7 сая төгрөг;
- **Увс аймаг дахь Статистикийн хэлтэс:** Шатах тослох материал зарцуулахдаа бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд заасан 3 хувийн хөнгөлөлтийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй 0.2 сая төгрөг;
- **Орхон аймаг дахь Статистикийн хэлтэс:** Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг буруу хэрэглэсэн. Бусад бараа үйлчилгээний зардлыг БҮТЭЗ-ийн ангиллаас зарцуулсан 0.09 сая төгрөг.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 4,382.4 сая төгрөг болж, өмнөх оноос 1,145.6 сая төгрөгөөр буюу 35.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Б	1	2	3=2-1
<b>Биет хөрөнгө</b>	<b>3,164.1</b>	<b>4,125.3</b>	<b>961.2</b>
Барилга, байгууламж, орон сууц	12.5	11.7	(0.8)
Авто-тээврийн хэрэгсэл	826.6	1,132.2	305.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,045.0	2,625.8	580.8

**Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Тавилга, аж ахуйн эд хогшил	280.0	355.6	75.6
Бусад үндсэн хөрөнгө	-	-	-
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>72.7</b>	<b>257.1</b>	<b>184.4</b>
Программ хангамж	71.9	256.3	184.4
Бусад биет бус хөрөнгө	0.8	0.8	-
<b>Дүн</b>	<b>3,236.8</b>	<b>4,382.4</b>	<b>1,145.6</b>

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант онд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр худалдан авсан 1,243.0 сая төгрөг, Нэгдсэн үндэстний байгууллагаас 71.9 сая төгрөг, Азийн хөгжлийн банкнаас 257.9 сая төгрөг, БНСУ-ын статистикийн газраас 121.9 сая төгрөг, Завхан аймгийн статистикийн хэлтэс орон нутгаас 4.7 сая төгрөгийн хөрөнгө хандиваар авч, шилжүүлэн авсан хөрөнгө 826.2 сая төгрөг, орон нутгийн засаг захиргааны нэгжээс үнэ төлбөргүй авсан 112.9 сая төгрөг, ТӨБЗГ-ын “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 2025 оны 168, 317, 882 дугаар тогтоолоор 60 нэр төрлийн 78.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж, бүртгэснээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын “Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах тухай” 2025 оны 209, 336, 889 дүгээр тогтоолуудаар 675.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан, 21 аймгийн Мал эмнэлгийн газарт компьютер тоног төхөөрөмжийг балансаас баланст шилжүүлсэн өгсөн 18.1 сая төгрөг, “дахин үнэлгээний хорогдол 179.6 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- **Хөвсгөл аймаг дахь Статистикийн хэлтэс:** Элэгдлээрээ өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй анхны өртөгтэй, 3 нэр төрлийн 3 ширхэг, 0.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна;
- **Өмнөговь аймаг дахь Статистикийн хэлтэс:** Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө санхүүгийн үр дүнгийн тайланд дутуу тайлагнасан 0.3 сая төгрөг, биет бус хөрөнгөд бүртгэлтэй ашиглахгүй байгаа программ хангамжуудыг данс бүртгэлээс хасаагүй 0.5 сая төгрөг;
- **Булган аймаг дахь Статистикийн хэлтэс:** Үндсэн хөрөнгийн шинжтэй 0.06 сая төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн.

**3.4.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 24.4 сая төгрөг болж, өмнөх оноос 22.4 сая төгрөг буюу 82.0 хувиар өссөн байна.

***Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл***

<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>Зөрүү</b>
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	1.5	0.4	(1.1)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.1	0.4	0.3
Байгууллагад төлөх өглөг	-	18.4	18.4
Хувь хүмүүст төлөх өглөг	0.3	5.2	4.9
<b>Дүн</b>	<b>2.0</b>	<b>24.4</b>	<b>22.4</b>

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Өр төлбөр дансны 24.4 сая төгрөгийн үлдэгдэлд Сангийн яам зарим зардлын санхүүжилтийг олгоогүйтэй холбоотойгоор үүссэн хувь хүнд өгөх өглөг, НДШ-ийн өр төлбөр байгаагаас Дорноговь аймгийн Статистикийн хэлтэс 0.8 сая төгрөг, Хэнтий аймгийн Статистикийн хэлтэс 0.6 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Статистикийн хэлтэс 0.3 сая төгрөг, Булган аймгийн Статистикийн хэлтэс 0.1 сая төгрөг, Архангай аймгийн Статистикийн хэлтэс 2.8 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс 0.2 сая төгрөг, Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс 2.2 сая төгрөг, Увс аймгийн Статистикийн хэлтэс 6.0 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтэс 4.1 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс 0.1 сая төгрөг, Нийслэлийн статистикийн газар 7.2 сая төгрөгийн өр төлбөр тус тус бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- **Булган аймаг дахь Статистикийн хэлтэс:** Тайлант хугацаанд үүссэн өглөгийг 0.08 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,182.5 сая төгрөг болж, 995.7 сая төгрөгөөр буюу 23.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо төгрөгөөр/

/сая

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Б	1	2	3=2-1
Хуримтлагдсан үр дүн	4,183.6	5,179.3	995.7
Өмнөх үеийн үр дүн	4,993.3	4,184.3	(809.0)
Тайлант үеийн үр дүн	(809.6)	995.0	1,804.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3.1	3.1	-
<b>Дүн</b>	<b>4,186.7</b>	<b>5,182.4</b>	<b>995.7</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо данс 995.7 сая төгрөгөөр өсөхөд тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан, харьяа байгууллагууд ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрээр хөрөнгийн дахин үнэлгээ хийж, үнэ шинэчлэн тогтоосон, хөрөнгө акталсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг улсын төсвөөс 40,851.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 6,458.3 сая төгрөгөөр бууруулж, 34,392.7 сая төгрөгөөр баталсан байна. Тухайлбал: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 3,776.6 сая төгрөг, хөрөнгийн зардал 1,743.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал, байр ашиглалтын зардал, гадаад дотоод томилолт, эд хогшил, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийг 1,599.6 сая төгрөгөөр тус тус бууруулжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төсвийг 29,907.1 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагч Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр 2 удаа 13.6 сая төгрөгийн зохицуулалт хийж, зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг улсын төсвийн 29,907.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 27,023.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 25,716.9 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 1,306.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Үндэсний статистикийн хорооны арилжааны банк дахь дансны мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 0.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байна.

Үндсэн үйл ажиллагааны зардлыг нийт 2,386.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Тухайлбал: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 895.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 66.0 сая төгрөг, эд хогшил, урсгал засвар зардлыг 48.8 сая төгрөг, дотоод томилолтыг 30.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,079.7 сая төгрөг, урсгал шилжүүлгийг 213.5 сая төгрөг, бусад зардлыг 51.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 25,716.9 сая төгрөг буюу 92.0 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	70405	Албан ёсны статистик	28,102.9	25,716.9	2,386.0	91.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагаа	19,481.8	18,232.8	1,249.0	93.6
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	10.8	1.4	9.4	13
1.3	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	53.6	53.3	0.3	99.4
1.4	80220	Холбооны суваг ашигласны хөлс	188.1	174.5	13.6	92.8
1.5	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	667.1	596.9	70.2	89.5
1.6	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	36.5	-	36.5	0
1.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	338.1	161.1	177.0	47.6
1.8	81508	Хүн амын тооллого	2,217.4	1,837.5	379.9	82.9
1.9	81510	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	3,106.8	2,968.0	138.8	95.5
1.10	81512	Ардчилсан засаглалын судалгаа	15.0	13.6	1.4	90.7
1.11	81513	Мал, тэжээвэр амьтдын тооллого	192.3	166.2	26.1	86.4
1.12	81514	Хэрэглээний үнийн судалгаа	72.3	35.6	36.7	49.2
1.13	81517	Статистикийн бусад тооллого, судалгаа	909.0	745.2	163.8	82
1.14	81526	Хагас жилийн мал тооллого	732.3	729.6	2.7	99.6
1.15	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1.2	1.2	-	100
1.16	81528	Малын ашиг шимийн судалгаа	80.6	-	80.6	0

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймаг, нийслэлийн төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс хандив, тусламж буюу олон улсын төслийн байгууллага Азийн хөгжлийн банк, Нэгдсэн үндэстний байгууллагаас тооллого судалгааны ажилд 712.3 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс тухайн төсөв захирагчид хуваарилсан, орон нутгийн нэмэгдэл 936.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 160.1 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас харьяа байгууллагуудад олгосон 5,016.2 сая төгрөг, нийт 6,825.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 2,053.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 3,410.8 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 660.2 сая төгрөг, бусад зардалд 455.2 сая төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулаагүй 245.2 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр хийгдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, 4 удаа тодотгосон байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, улсын төсвийн урсгал төсвөөр 17, хандив тусламжийн хүрээнд 3, нийт 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах “Үндэсний статистикийн хороо, орон нутгийн байгууллагуудын тоног төхөөрөмж” 3 багц тендерийг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 233 дугаар тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газар хэрэгжүүлсэн байна. Тус газраас ирүүлсэн албан бичгийг үндэслэн, шалгарсан компаниудтай гэрээ байгуулж, машин тоног төхөөрөмжийг хүлээн авч, акт үйлдэн, санхүүжилтийг тухай бүр улсын төсвөөс санхүүжүүлэн ажилласан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсөв 2,000.0 тэрбум төгрөг үүнээс 1,804.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, хугацаандаа нийлүүлээгүй 1 бараанд 6.5 сая төгрөгийн алданги тооцон суутгаж, гэрээний гүйцэтгэлээр 1,797.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 202.1 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Улсын төсвийн урсгал болон төслийн санхүүжилтээр хийгдэх худалдан авах ажиллагааг нээлтэй 4, харьцуулалтын 9, шууд худалдан авахаар 7, нийт 20 арга хэмжээ төлөвлөснөөс нээлттэй тендер 5, харьцуулалтын 7, давхардсан тоогоор 20 удаа цахимаар зарлаж, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Төслийн санхүүжилтээр хийгдэх 2 арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэргүй болсон бөгөөд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасан нөхцөл байдал үүсэж, гэрээг байгуулах боломжгүй болж, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр хийгдэх худалдан авах ажиллагаанаас 121.1 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Төлөвлөгөөнд тусгасны дагуу 17 худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шалгарсан компанитай гэрээ байгуулж, гэрээний гүйцэтгэл 100 хувь байна.

**Аудитын илрүүлэлт:**

- **Үндэсний статистикийн хороо:** тайлант онд нийт 39.3 сая төгрөгийн бараа материалын төсөвт өртгийг хувааж, 1 аж ахуй нэгж, байгууллагатай 3 шууд гэрээ байгуулан худалдан авсан.

**3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд дараах арга хэмжээ, зорилтот түвшнийг баталжээ.

Хүснэгт 10. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны үзүүлэлт	2025 оны зорилтот түвшин	Үр дүн	Хувь	
<b>Үндэсний статистикийн хороо</b>				
1.1.1	Захиргааны статистикийн мэдээлэл, тайлангийн нэр, төрөл	403	Тайлант онд 43 төрийн байгууллага, яам, агентлагаас 415 маягтаар захиргааны статистикийн мэдээллийг нэгтгэн цуглуулсан.	103.0
1.1.2	Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтсээс ирүүлдэг мэдээ, тайлан	55	Тайлант онд ҮСХ-ны даргын А/178 тоот тушаалын дагуу 56 төрлийн мэдээ, тайланг сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар хүлээн авсан.	102.0
1.2.1	Монгол Улсын статистикийн эмхэтгэл	1	Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2024-ийг 25 бүлэгтэйгээр Монгол, Англи хэл дээр бэлтгэн боловсруулж, статистикийн мэдээллийн нэгдсэн санд цахимаар байршуулж, хэвлэмэл байдлаар хүргүүлсэн.	100.0
1.2.2	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сарын бюллетень, танилцуулга	36	Сар бүр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгыг Монгол, Англи хэлбэрээр 2 ширхэг, жилд 24 ширхэг танилцуулгыг бэлтгэн, хэрэглэгчдэд тархаасан. Мөн сар бүр нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг сэтгүүлчдэд хүргэх зорилгоор 12 удаа презентаци бэлтгэн тархаасан.	100.0
1.3.1	Инфографик танилцуулга	20	Сар бүрийн статистикийн танилцуулгад ордог салбаруудын мэдээллээр дунджаар 20 ширхэг инфографикийг хэрэглэгчдэд тархаасан	100.0
1.3.2	Тооллого, судалгааны үр дүн	10	ӨНЭЗС, АХС, Ардчилсан засаглал судалгаа, Малын хагас жилийн түүвэр судалгаа, Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого, Дотоодын жуулчдын түүвэр судалгаа, Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийн судалгаа, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (нэмэх), Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн судалгаа, Зохистой хөдөлмөр: 2030 он хүртэлх ТХЗ-ын хэрэгжилт, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгүүдийг боловсруулж, СМНС-д байршуулж, тархаасан. /11 судалгааны үр дүн/	110.0
1.3.3	Мэдээллийн нэгдсэн сангийн тайлан /1212.mn/	850	Шинэчлэн сайжруулсан СМНС (www.1212.mn)-д 56 бүлгийн 859 үзүүлэлтийг 7 хоног, 15 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар шинэчлэн тархаасан.	101.0
1.4.1	Шинээр боловсруулах болон шинэчлэх аргачлал, ангиллын тоо	6	2025 онд Хүний хөгжлийн индекс тооцох аргачлал, ДНБ-ийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлал, Байр сууцаар хангах, нийтийн хоолны салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Судалгааны баримт бичгийн стандартчилал, Зохистой хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүдийг тооцох гарын авлага зэргийг шинэчлэн боловсруулж мөрдөж байна.	100.0
1.5.1	Статистикийн мэдээллийн санд суурилж, нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлт	35	Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн тоон мэдээлэлд үндэслэж, нийгэм, эдийн засгийн 35 салбарын жилийн дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж, тархаасан..	100.0
1.6.1	Тооллого	2	2025 онд Статистикийн тухай хуульд заасны дагуу Хүн ам, орон сууцны завсрын тооллого, Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн болон малын хагас жилийн тооллогыг түүвэр судалгааны аргаар амжилттай зохион байгуулсан.	100.0

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.6.2	Судалгаа	3	Статистикийн тухай хуульд заасны дагуу 2025 онд улирал бүр ӨНЭЗС, АХС, Ардчилсан засаглал судалгааг зохион байгуулсан. Мөн 2025 оны 11 дүгээр сард Дотоодын жуулчдын түүвэр судалгааг улсын хэмжээнд анх удаа зохион байгуулсан.	100.0
-------	----------	---	--	-------

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 1 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 6 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасан бөгөөд хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн 104.4 хувийн биелэлттэй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор П.Амарсанаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/267 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 24,411.9 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 244.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнг нэгтгэхэд тайлант онд 23,188.6 сая төгрөгийн 111 орлогын гүйлгээ, 10,752.9 сая төгрөгийн 440 зарлагын гүйлгээний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод мэдээлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- **Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс:** Шилэн дансны цахим системд 20 мэдээллийг мэдээлээгүй, 21.2 сая төгрөгийн дүн бүхий 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

#### 4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### 1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой асуудал

##### Албан шаардлага:

Илрүүлэлт: Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас хоцроож, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/267 дугаар албан бичгээр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-т “Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу ..... төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны

дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### Харьяа байгууллагад илэрсэн бусад хууль тогтоомжийн асуудал:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн нийт 24.2 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 24.2 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

##### Аудитын илрүүлэлт:

- **Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс:** Ажилтны ажлын цаг ашиглалтын бүртгэлийг хөтөлж архивлаагүй, цалингийн тооцооны хүснэгт, цалингийн картыг зааврын дагуу хөтлөөгүй, ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл хөтлөөгүй.

#### 4.4 Судалгааны үр дүн

Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд судалгаа авч нэгтгэн дүгнэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд ҮСХ-ны 2025 оны Б/18 дугаар тушаалаар 298 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр албан хаагчдын орон тоог өөрчлөөгүй бөгөөд 2026 оны төсөвт 22-оор бууруулан баталсан байна.
- ҮСХ-ны даргын 2025 оны Б/18 дугаар тушаалаар хоолны хөнгөлөлтийг 19.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 1.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтөд нийт 3,167.5 сая төгрөгийг баталж, 2,847.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Гадаад томилолтын 1 арга хэмжээний хүрээнд Австралийн хоёр талт хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагын "Шууд тусламжийн хөтөлбөр"-ийн санхүүжилтээр Үндэсний статистикийн хорооны даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар нэмэлт санхүүжилтийн данснаас 34.1 сая төгрөг зарцуулсан байна.
- Тайлант онд сургалт, семинарын зардалд 172.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 178.0 сая төгрөг зарцуулсан байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан Хүн амын тооллого, Мал тоолох апп, малын үндэсний бүртгэл мэдээллийн санг ашиглах талаар видео контент бэлтгэхээр 8 гэрээ байгуулж, 21.0 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

#### 4.5. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 114.7 сая төгрөгийн 20 зөрчил илэрснээс 0.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 67.0 сая төгрөгийн 5 албан шаардлага, 47.6 сая төгрөгийн 14 зөвлөмж өгснийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Акт	1	0.1	1	0.1	100.0
2	Албан шаардлага	5	67.0	5	67.0	100.0
3	Зөвлөмж	14	47.6	14	47.6	100.0
4	Хариуцлага тооцуулах албан шаардлага	-	-	-	-	100.0
<b>Нийт дүн</b>		<b>20</b>	<b>114.7</b>	<b>20</b>	<b>114.7</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дараагийн аудитаар төсвийн төлөвлөлтийг бодитой төлөвлөсөн эсэх, цалингийн сан, орон тооны хязгаарыг баталсан хууль, тогтоомжийн хүрээнд дагаж мөрдсөн эсэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтын асуудлыг нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 23 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 12 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 11 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан 11 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 155.4 сая төгрөгийн 26 алдаа, зөрчлийг илрүүлж, аудитын явцад 8.7 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 0.8 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 17.2 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 128.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 146.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 97.4 сая төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

#### 1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа газруудын зөрчилтэй холбоотой.

**Илрүүлэлт:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 23 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 146.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 0.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 17.2 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 128.7 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

### 5.2 Зөвлөмж

**Илрүүлэлт:** Өгөгдлийн ажлын урсгал автоматжуулах программ (ETL)-н лиценз 63.4 сая төгрөг, R болон Python программчлалын хэлний пакеж удирдах программын лиценз 49.2 сая төгрөг, нийт 112.7 сая төгрөгийг сар бүр тохируулах бичилт хийж бүртгээгүй, тайлант оны зардал бүртгэж, тайлагнасан байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3.7-д

“Тайлант үед хамаарах бараа, ажил үйлчилгээний зардлыг дараах байдлаар бүртгэнэ<sup>1</sup>” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Урьдчилж гарсан зардлыг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан журамд заасны дагуу тайлант хугацаанд хуваарилан зардалд хүлээн зөвшөөрч, бүртгэж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> (г) зардлыг урьдчилан төлөх үед: Дт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/ Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө  
(д) урьдчилж төлсөн зардлаас тухайн тайлант үед хэрэгжсэн үед: Дт Зардал /нэр төрлөөр/ Кт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Алдаа					
		Нийт дүн		Залруулсан		Залруулаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган аймаг дахь СХ	1	540.8	1	540.8	-	-
		1	580.0	1	580.0	-	-
		1	81.6	1	81.6	-	-
2	Өмнөговь аймаг дахь СХ	1	2,920.0	1	2,920.0	-	-
3	Ховд аймаг дахь СХ	1	3,404.7	1	3,404.7	-	-
4	Үндэсний статистикийн хороо	1	1,210.0	1	1,210.0	-	-
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>8,737.1</b>	<b>6</b>	<b>8,737.1</b>	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын зөрчил							
		Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймаг дахь СХ	1	24,242.8					1	24,242.8
		1	-					1	-
		1	-					1	-
		1	-					1	-
<b>ТЕЗ дүн</b>		<b>4</b>	<b>24,242.8</b>	-	-	-	-	<b>4</b>	<b>24,242.8</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил							
			Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймаг дахь СХ	Тээвэр, шатахууны зардлыг олгохдоо Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан нормоор тооцож олгоогүй.	1	-	-	-	1	-	-	-
2	Говьсүмбэр аймаг дахь СХ	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 166.2 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү тооцож олгосон байна	1	166.2	1	166.2	-	-	-	-
		Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүй боловч, ур чадварын нэмэгдэл олгосон байна	1	742.0		-	1	742.0		-
		Жилийн эцсийн байдлаар 661.5 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгдээгүй	1	661.5		-	1	661.5		-
		Анхан шатны баримтын бүрдэл дутуу албан томилолтын зардал олгосон байна	1	1,040.0		-	1	1,040.0		-
3	Дорноговь аймаг дахь СХ	Байгууллагын албан хаагчид болон гэрээгээр ажил гүйцэтгэдэг судлаачдын цалинг нийгмийн даатгалын тайланд үнэн зөв тайлагнасан боловч татварын байгууллагад 3,110,000 төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	3,100.0		-		-	1	3,100.0
		Байгууллагын албан хаагчдад тайлант оны 2,3,5 дугаар сарын илүү цагийн нэмэгдэл хөлсийг 5 дугаар сард олгосон байна. Гэвч илүү цагийн нэмэгдэл хөлсийг тооцоолохдоо үндсэн цалингаас тооцоолсон бөгөөд 4 албан хаагчид 1,864,708 төгрөгийн нэмэгдэл хөлсийг дутуу олгосон байна. Байгууллагад нөхөн олгох цалингийн зардал байхгүй тул цаашид холбогдох хууль, журмын дагуу дундаж цалин хөлснөөс тооцох талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.	1	-	-	-	-	-	1	-
4	Дорнод аймаг дахь СХ	Хоол, унааны хөнгөлөлтийг албан томилолтын зардалтай давхардуулан олгосон	1	295.0	1	295.0	-	-	-	-
5	Орхон аймаг дахь СХ	Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг буруу хэрэглэсэн. Бусад бараа үйлчилгээний зардлыг БҮТЭЗ-ийн ангиллаас зарцуулсан	1	86.9		-		-	1	86.9

6	Төв аймаг дахь СХ	Судалгааны урамшуулал олгохдоо цахим төлбөрийн баримт шивж баталгаажуулаагүй.	1	-		-		-	1	-
		Жолооч хөлсөлж явахдаа ажлын хөлс олгоогүй, төрийн албан хаагчдад олгох томилолтын зардал бодож олгосон байна	1	2,700.0		-		-	1	2,700.0
7	Увс аймаг дахь СХ	Тээвэр шатахууны зардлаас 300.0 мянган төгрөгийг хуурамч баримтаар зарцуулсан	1	300.0	1	300.0		-	-	-
		Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндэслэх шийдвэргүйгээр нэмэгдүүлэн олгосон	1	328.7		-		-	1	328.7
		Шатах тослох материал зарцуулахдаа бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд заасан 3 хувийн хөнгөлөлтийн үлдэгдэл 156.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	156.4		-		-	1	156.4
8	Ховд аймаг дахь СХ	Биет бус хөрөнгөд бүртгэлтэй ашиглахгүй байгаа программ хангамжуудыг данс бүртгэлээс хасаагүй	1	450.0		-		-	1	450.0
9	Хөвсгөл аймаг дахь СХ	Элэгдлээрээ өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй 4000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 3 нэр төрлийн 3 ш хөрөнгө бүртгэлтэй байна.	1	4,000.0		-		-	1	4,000.0
10	Нийслэлийн Статистикийн газар	Нийслэлийн автобаазтай гэрээ хийж суудлын автомашинаар хийсэн ажил нотлогдохгүй байна.	1	8,526.7	-	-	1	8,526.7		-
		Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлаас түүвэрлэн үзэхэд замын хуудас нь тайлангүй зарцуулалт дээр нь хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	6,276.8		-	1	6,276.8		-
		Тогтмол зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил дансандаа бүртгэсэн байна	1	5,227.5		-		-	1	5,227.5
11	Үндэсний статистикийн хороо	Өгөгдлийн ажлын урсгал автоматжуулах программ (ETL)-н лиценз 63,416.0 мянган төгрөг, R б+олон Python программчлалын хэлний пакеж удирдах программын лиценз 49,250.0 мянган төгрөг, нийт 112,666.0 мянган төгрөгийг сар бүр тохируулах бичилт хийж бүртгээгүй, тайлант оны зардал бүртгэж, тайлагнасан байна.	1	112,666.0		-		-	1	112,666.0
<b>ТЕЗ дүн</b>			<b>20</b>	<b>146,723.7</b>	<b>3</b>	<b>761.2</b>	<b>6</b>	<b>17,247.0</b>	<b>11</b>	<b>128,715.5</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1312/АО111371

Улаанбаатар хот

САГ-2026/22/НА-СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас хоцроож, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/267 дугаар албан бичгээр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д "Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу ..... төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д "Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны дарга (Б.Батдаваа), Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Төмөрхуяг) нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1313/АД111371

Улаанбаатар хот

САГ - 2026/22/НА-СТА - ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 23 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 146,723,658.90 /Нэг зуун дөчин зургаан сая долорон зуун хорин гурван мянга зургаан зуун тавин найман төгрөг ерэн мөнгө/-ний зөрчил илрүүлж, 761,200.00 /Долоон зуун жаран нэгэн мянга хоёр зуу/ төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 17,246,958.90 /Арван долоон сая хоёр зуун дөчин зургаан мянга есөн зуун тавин найман төгрөг ерэн мөнгө/-ний 6 албан шаардлага хүргүүлж, 128,715,500.00 /Нэг зуун хорин найман сая долоон зуун арван таван мянга таван зуу/ төгрөгийн 11 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага

өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны дарга (Б.Батдаваа), Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Төмөрхуяг), Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газрын дарга (Н.Мөнхбаяр) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН